



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 10 он 08
сарын 16 өдөр

Дугаар 31-2 / 547

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.ДОРЖХАНД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаартай “Асуулга тавих тухай” албан бичигтэй танилцан Улсын онцгой комиссын Шуурхай штабаас зохион байгуулсан үйл ажиллагаатай холбогдуулан дараахь хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын онцгой комиссын Шуурхай штабт өргөдөл гомдол хянан шийдвэрлэх үүрэгтэй Ажлын хэсэг байгуулсан бөгөөд 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 8 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд 50 улс орноос 28296 иргэний өргөдлийг хүлээн авч өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, бага насны хүүхэдтэй, жирэмсэн, оюутан, эрүүл мэндийн шалтгаантай, санхүү, орон байргүй болсон, ар гэрийн гачигдалтай зэрэг шалтгааныг үндэслэн 15708 иргэнийг татан аваад байна. Үүнээс 9654 иргэнийг агаараар татан авсан бөгөөд одоо 55 улс орноос 12727 иргэн эх орондоо ирэх хүсэлт гаргаад байна.

Дээрх татан авсан иргэдээс 0-5 насны хүүхэд 695 буюу 4.4 хувь, 55 наснаас дээш насны эмэгтэй 1268 буюу 10.1 хувь, 60 наснаас дээш насны эрэгтэй 459 буюу 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд хандсан иргэдийн нэрсийг ил тод болгож, Элчин сайдын яамны албан ёсны веб сайтад байршуулсан боловч зарим иргэдийн зүгээс хувь хүний нууц, эрүүл мэндийн шалтгааныг бусдад зарлалаа гэх зэргээр дургүйцлээ илэрхийлж, гомдол гаргаж байсан.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоо, судалгаагаар “КОВИД-19” халдварын цар тахал 2-3 жил үргэлжлэх магадлалтай тул Монгол Улсын хилийг хэзээ нээх нь тодорхойгүй байна.

Салбар хоорондын эрсдэлийн үнэлгээний баг 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдөр эрсдэлийн үнэлгээг 10 дахь удаагаа хийхэд КОВИД-19 халдварын

2042883

тархалт Монгол Улсад зөөвөрлөгдөн орж ирэх, улмаар хүн амын дунд тархах “Өндөр” эрсдэлтэй гэж дүгнэсэн.

3. Гадаад улс орноос 2020 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 15171 иргэнийг зохион байгуулалттайгаар татан авч тусгаарласан бөгөөд 8 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийслэлд 36, орон нутагт 14, нийт 50 тусгаарлах байранд 3410 иргэнийг тусгаарлан ажиглаж байна.

Тусгаарлагдсан иргэдэд Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан хоолны цэсний дагуу 2800-3200 илчлэгтэй хоол хүнсээр өдөрт 5 удаа үйлчилж байгаа бөгөөд хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл, шаардлага, хүнсний аюулгүй байдалд Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж байгаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмын дагуу Улсын онцгой комиссын Шуурхай штабаас зочид буудлыг тусгаарлах байрны зориулалтаар сонгохдоо нэгэн зэрэг 40-өөс дээш тооны иргэдийг хүлээн авах (1 өрөөнд 1 хүнийг тусгаарлах), ариун цэврийн өрөө (гар нүүр угаах, усанд орох, бие засах зэрэг эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх), хоол үйлдвэрлэл (зориулалтын гал тогоо, мэргэжлийн ажилтантай байх), цагдаагийн хамгаалалт гаргахад тохиромжтой эсэхийг харгалзан аж ахуйн нэгжтэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 266 зочид буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас тусгаарлах байраар ашиглахад тавигдаж буй шаардлагыг хангасан 53 аж ахуйн нэгжийн зочид буудал байгаагаас 40 зочид буудал, 2 эмнэлэг, 3 амралтын газар, 3 сувилал, 1 сургуулийн дотуур байр, 1 судалгааны төв тусгаарлах байраар ажиллахыг зөвшөөрч хамтран ажиллаж байна.

Хамтран ажиллах санал тавьсан 13 аж ахуйн нэгжийн зочид буудал 1 өрөөнд 1 хүнийг өдрийн 50000 төгрөгөөр байршуулах боломжгүй, тусгаарлагдсан иргэд өндөр зэрэглэлийн зочид буудлын үйлчилгээ шаарддаг, хэл амаар доромжилдог, эд хогшил эвддэг, гадаадын хөрөнгө оруулагч нь зөвшөөрөөгүй, ажиллах хүний нөөцгүй, бизнесийн нэр хүндэд нь сөргөөр нөлөөлнө гэж үзсэн зэрэг шалтгааны улмаас татгалзсан.

Эрүүл мэндийн яамнаас олон нийтийн дунд “КОВИД-19” халдвар тархсан үед нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр баригдсан нийслэлийн эх, хүүхдийн 300 ортой эмнэлгийг 1000 ортой болгон өргөтгөн зохион байгуулж ашиглахаар төлөвлөсөн.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)-тай хамтран Бүгд Найрамдах Польш Улсад санхүүгийн хүнд байдалд ороод байсан 6 иргэн, Малайзын Холбооны Улс, Тайландын Вант Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 7 иргэн, Бүгд Найрамдах Чех Улсаас 187 иргэн, нийт 200 иргэний онгоцны тийз, тусгаарлах байр, халдварын шинжилгээний төлбөр, нийт 660,000,000 төгрөгийн зардлын асуудлыг нь шийдвэрлэв.

4. “КОВИД-19” халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд 290 аж ахуйн нэгж байгууллага, 256 иргэн 3.5 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө, 3.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, материалыг Улсын онцгой комисст хандивласныг хүлээн авч 2.5 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө, 2.5 тэрбум төгрөгийн бараа материалыг зарцуулаад байна. Хандивын зарцуулалтын тайлан мэдээг Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулж, шилэн дансанд болон neta.gov.mn веб сайтад байршуулах зэргээр ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

5. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 26 дугаар тушаалаар “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний стратеги, төлөвлөгөө”-г батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллав.

Монгол Улсын Шадар сайд



Я. Содбаатар
Я.СОДБААТАР